



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/180

Ховд

Захирамжийн хэрэгжилтийг сунгаж,
цагийн хуваарь тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт Covid-19-ын тохиолдол батлагдсантай холбогдуулан Аймгийн төв, сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бар, ресторан, караоке, зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагааг түр хязгаарлах тухай аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А\176 дугаартай захирамжийн хэрэгжих хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 00.00 цагаас 04 дүгээр сарын 05-ны өдрийн 23.00 цаг хүртэл сунгасугай .

2. Аймгийн нутаг дэвсгэрт хязгаарлалт тогтоосонтой холбогдуулан Төрийн байгууллагуудын албан хаагчдын 30 хүртлэх хувийг ажиллуулан бусад албан хаагчдыг гэрээсээ ажиллах боломжоор хангахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Ховд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа банкуудын үйл ажиллагаа явуулах цагийн хуваарийг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд 09.00-15.00 цагийн хооронд байхаар тогтоон хэрэгжүүлж ажиллахыг банкуудын удирдлагад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02.1070
D/Zah-A/180-Bo